

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Биеийнтамир, спортын улсын хороо

Хяналт- шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Дэстүшмэл, ТЗ-6

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг. 8-р хороо, Бага тойруу-55, Спортын төв ордон

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Салбарын хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын стратеги, төсөл хөтөлбөр, гэрээт ажлын хэрэгжилт, агентлагийн газар, хэлтэс, орон нутгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлж, зөвлөмж, дүгнэлт гаргаж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;
- 2.Агентлагийн газар, хэлтэс, орон нутгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг боловсруулж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;
- 3.Агентлагийн газар, хэлтэс, аймаг, нийслэл, дүүргийн хороодод хийх хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, тайлан гаргаж, тэмцээн уралдааны зохион байгуулалтыг үнэлж, дүгнэлт зөвлөмж гаргах;
- 4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.Биеийн тамир, спортын тухай хууль, Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого, цогц хөтөлбөрийн хэрэгжилт, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх;</p> <p>2.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг тухайн жилд хөгжүүлэх үндсэн чиглэл, Үндэсний хөтөлбөрүүд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын чиг үүрэгт хамааралтай заалтуудын хэрэгжилтийн мэдээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;</p> <p>3.Биеийн тамир, спортын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг дагаж гарсан дүрэм журам, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.</p>	<p>Хяналт шинжилгээ, үнэлгээг ЗГХЭГ-аас тогтоосон хугацаа, журам, аргачлалыг баримтлан хийж, тайланг хүргүүлсэн байна.</p> <p>Хяналт шинжилгээ, үнэлгээг ЗГХЭГ-аас тогтоосон хугацаа, журам, аргачлалыг баримтлан хийж, тайланг хүргүүлсэн байна.</p> <p>Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг гаргасан байна.</p>	Г Г Г
	1.Агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн хороодын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнасан байна.	МОНГОЛ УЛС Г ТӨВШООРОВ ДАЧИНАДБАНЫ ЗӨВЛӨЛ

2 дугаар зорилтын хүрээнд	2.Агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн хороодын үйл ажиллагаанд хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланда хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнасан байна.	Г
	3.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж, аргачлал боловсруулах.	Удирдамж, аргачлал боловсруулсан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Аймаг, нийслэл, дүүргийн хороодын үйл ажиллагааны чиглэлээр хяналт шалгалтын төлөвлөгөө удирдамж боловсруулж, батлуулах;	Удирдамж, аргачлалын дагуу зөвлөмж боловсруулсан байна.	Г
	2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг холбогдох байгууллагад хүргэх;	Тайланг зохиц байгууллагад хүргүүлсэн байна.	Г
	3.Олон улсын болон улсын хэмжээний тэмцээн, уралдааны зохион байгуулалтад хяналт шинжилгээ үнэлгээ хийх.	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан гаргасан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн байна.	Г
	2.Хариуцсан чиг үүргийн дагуу байгууллага иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг тогтоосон хугацаанд судалж шийдвэрлэх;	Өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Г
	3.Хэлтсийн даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, биелэлтийг хангаж тогтоосон хугацаанд тайлagnah үр дүнг үнэлж дүгнүүлэх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө түүний хэрэгжилтийг хангасан байна.	Г
	4.Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам стандартад нийцсэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд оролцох;	Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байх	Г

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> <li>- эрх зүй /042/;</li> <li>- спорт /1014/;</li> <li>- төрийн удирдлага /041303/;</li> <li>- спортын менежмент.</li> </ul>



Мэргэшил	Төрийн албаны богино, дунд хугацааны сургалтад хамрагдсан байх.		
Туршлага	Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр болон тухайн салбарт 3-аас доошгүй жил ажилласан байх.		
Үр чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх;</li> <li>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, харьцуулалт хийх;</li> <li>- хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын явц, үр дүнг тайлагнах, зөвлөмж, дүгнэлт гарах;</li> <li>- хяналт шинжилгээ, үнэлгээний хийхдээ мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийтэй бус байдлыг илрүүлэх;</li> <li>- бусад.</li> </ul>	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;</li> <li>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, харилцааны соёлыг эрхэмлэх;</li> <li>- өөрийн үйл ажиллагааны үр дунд хяналт тавьж чаддаг байх;</li> <li>- бүтээлч, санаачилгатай ажиллах, үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;</li> <li>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх;</li> <li>- бусад.</li> </ul>	
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа эерэг мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;</li> <li>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах;</li> <li>- мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах;</li> <li>- хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх;</li> <li>- бусад.</li> </ul>	
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- харилцааны соёлыг эрхэмлэх,;</li> <li>- албан ажлын чиг үүргийн дагуу зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх;</li> <li>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи, ашиглах чадвартай байх;</li> <li>- төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх;</li> <li>- англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх;</li> <li>- бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх;</li> <li>- худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх;</li> <li>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;</li> <li>- монгол бичгээр уншиж, бичих чадвартай байх.</li> </ul>	



#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга.

Албан тушаалд шууд харьялан  
удирдуулах албан тушаалын нэр, тоо:


Бусад харилцах субъект:

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн газар, хэлтэс;
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдийн ажилтан;
- Иргэн хуулийн этгээд.

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг  
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,  
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын  
шийдвэр:

Албан тушаал:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА  
  
Гарын үсэг (Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр)  
2020 оны 09 дугаар сарын 28-ны өдөр  
9020080967 9111891

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо:

20 09 09

Дугаар: 309

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

Шийдвэрийн огноо: 2020.9.28

Дугаар: 6/08

(тамга/тэмдэг)

ДАРГА Ц. ШАРАВЖАМЦ

2020 оны 9 дугаар сарын 28-ны өдөр

